



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/228

Багануур

Журам шинэчлэн батлах тухай

“Багануур” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.9.10 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадны машинд нүүрс ачиж борлуулах журам” –ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэлтэс, алба, хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэр борлуулалтын алба /Т.Бямбажаргал/-д, хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Д.Түвшинжаргал/, Дотоод хяналт шалгалтын алба /Б.Наранчимэг/-нд тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан 2013 оны А/244 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НОМИНЧУЛУУН



Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 сарын 30 өдөр
№1111 тоот тушаалын хавсралт №1

ГАДНЫ АВТОМАШИНД НҮҮРС АЧИЖ БОРЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Журмын зорилго нь "Багануур" ХК-ийн нүүрс ачилтын талбайгаас автомашинд нүүрс ачиж борлуулахтай холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү журам нь "Багануур" ХК-ний нийт ажилтнууд, гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтнууд болон нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан аж ахуй нэгж байгууллага, хувь хүн бүрд адил хамаарна.

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- | | | | |
|------|---|---|--|
| 3.1 | ГЗ | - | Гүйцэтгэх захирал |
| 3.2 | ТДЗ | - | Тэргүүн дэд захирал |
| 3.3 | ҮТЭДЗ | - | Үйлдвэр технологи эрхэлсэн дэд захирал |
| 3.4 | ХАБЭА | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй |
| 3.5 | ТехБХ | - | Технологийн бодлогын хэлтэс |
| 3.6 | СЭЗБХ | - | Санхүү эдийн засгийн бодлогын хэлтэс |
| 3.7 | ҮБА | - | Үйлдвэр борлуулалтын алба |
| 3.8 | ҮАМХ | - | Үйчилгээний авто машины хэсэг |
| 3.9 | ЗХ | - | Засварын хэсэг |
| 3.10 | ТАМАХ | - | Технологийн автомашины ашиглалтын хэлтэс |
| 3.11 | МТА | - | Мэдээллийн технологийн алба |
| 3.12 | ДХША | - | Дотоод хяналт шалгалтын алба |
| 3.13 | ААНБ | - | Аж ахуй нэгж, байгууллага |
| 3.14 | Гэрээт харуул хамгаалалт алба гэж "Багануур" ХК-тай харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж буй компанийг ойлгоно. | | |

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 4.1 Гадны автомашиныг Даваагаас Баасан гаригт 9.00 – 16.00 цагийн хооронд ачаалал ихэссэн үед Бямба, Ням гаригт 09.00 – 14.00 цагийн хооронд шалган нэвтрүүлэх 12-р постоор гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтан нь аюулгүй ажиллгааг хангах чиглэлээр зааварчилгаа бүхий дугаар өгч, бүртгэл хөтлөн нэвтрүүлнэ.
- 4.2 Автомашины жолооч нь автожингээр тээврийн хэрэгслийн ачаагүй үеийн жинг хэмжүүлэхдээ нүүрсийг хаана буулгах тухай аймаг, сум, дүүрэг, баг, хорооны тодорхойлолтыг жингийн бүртгэгчид хянуулна.

- 4.3 Гэрээт харуул хамгаалалтын албанд ҮБА –ны ээлжийн дарга нар өдөр бүр нүүрсийг хаанаас ачуулах чиглэлийг өгөх ба үүний дагуу гэрээт харуул хамгаалалтын ажилтан нь гадны автомашинуудыг дэс дараалалтай, эмх журамтай дагуулж нүүрс ачих талбайд хүргэнэ.
- 4.4 Нүүрсийг склад болон амнаас ачуулна. Жижиг оврын автомашин болон чиргүүлтэй автомашинуудыг складнаас, бусад автомашиныг зааж өгсөн нүүрс олборлолтын амнаас ачуулах ба нүүрс ачих тоног төхөөрөмжөөс 100м-ээс доошгүй, аюулгүй зайд зогсоож технологийн автомашиныг ачсаны дараа оруулна.
- 4.5 Экскаваторын машинч, туслах, гидро экскаватор болон дугуйт ачигчийн операторууд нүүрс ачуулахаар орж ирсэн гадны автомашинуудыг дарааллын дагуу ачих ба жижиг оврын автомашины жолооч нүүрс ачих ажлыг өөрөө хариуцна.
- 4.6 Нүүрс ачсан автомашинууд авто жин дээр ачаатай үеийн жинг тогтоолгон ачаа жингийн хуудсаа авч тусгайлан зассан талбайд автомашинаа байрлуулж, нүүрсний төлбөрийг компанийн касс эсвэл шалган нэвтрүүлэх 12 постонд байрлах ажилтанд нүүрсний төлбөрөө төлөөд ажлын өдөр 21.00 цагт, амралтын өдөр 18.00 цагт багтан шалган нэвтрүүлэх 12-р постоор буцан гарна. Хэрэв гарч амжаагүй бол дараагийн өдөр гарна.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛГААНД ОРОЛЦОЖ БУЙ ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 СЭЗБХ-ийн эрх
 - 5.1.1 "Багануур" ХК-тай "Худалдах худалдан авах" гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллага нь нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрөө нүүрсээр тооцох хүсэлт гаргасан албан тоотод Гүйцэтгэх захирал цохолт хийх ба түүнийг үндэслэн Тэргүүн дэд захирал, СЭЗБХ-ийн дарга зөвшөөрөл олгох
 - 5.1.2 ҮБА-ны авто жингийн бүртгэгчээс авто пүүний дэлгэрэнгүй тайланг өдөр бүр өдрийн тайланг, сар бүр сарын эцсийн нэгтгэл тайланг, шаардлагатай тохиолдолд заасан хугацааны тайланг гаргуулан авах
 - 5.1.3 Хоорондын тооцоогоор нүүрс авч буй ААНБ-тай төлбөр тооцоотой холбоотой маргаан гарсан тохиолдолд нүүрс олголтыг зогсоох
- 5.2 СЭЗБХ-ийн үүрэг
 - 5.2.1 Нүүрсний үнэ өөрчлөгдөх үед тогтоол шийдвэрийг тухай бүр мөрдүүлж түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах
 - 5.2.2 Мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч нь нүүрс болон бусад төрлийн түүхий эд худалдан авагч нарт ачаа жингийн хуудсыг үндэслэн кассын орлогын баримтыг олгох
 - 5.2.3 Мөнгөн хөрөнгийн нярав нь ачаа жингийн хуудас, кассын орлогын баримт зэргийг үндэслэн бэлэн мөнгө тушаасан баримт олгох
 - 5.2.4 Хоорондын тооцоогоор нүүрс авч буй ААНБ-н автомашины жолоочид үлдэх ачаа жингийн хуудасны баримт бүр дээр мөнгөн хөрөнгийн нярав нь тэмдэглэл хийн гарын үсэг тамгаар баталгаажуулж өгөх

- 5.2.5 Мөнгөн хөрөнгийн нярав нь Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, СЭЗБХ-ийн даргын цохолт, ҮБА-ны даргын цохолт, авлагын нягтлан бодогчийн цохолт, ААНБ-ын гэрээ зэргүүдийг үндэслэн борлуулагдаж байгаа нүүрсний төлбөр тооцоог тухай бүр хөтөлж дээрхи цохолтууд болон гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэхгүй байх
- 5.2.6 Нүүрсний төлбөр тооцоог харилцагч банкаар авхуулж буй тохиолдолд банкны ажилтанг 12-р постын дэргэдэх байранд ажиллуулах
- 5.2.7 Банкнд тушаагдсан тухайн өдрийн нүүрсний төлбөрийг авлагын нягтлан бодогч, мөнгөн хөрөнгийн нярав нар дараа өдөр нь тулгаж, зөрүүтэй тохиолдолд банкны ажилтантай тооцоо нийлж ажиллах
- 5.2.8 Мөнгөн хөрөнгийн нярав нь нүүрс худалдан авагчийн нүүрсийг хаана буулгах тухай аймаг, сум, дүүрэг, баг, хорооны тодорхойлолт, ачаа жингийн хуудас, кассын орлогын баримт зэргүүдийг анхан шатны баримтанд бүрдэл болгон явах
- 5.2.9 Хоорондын тооцоогоор нүүрс авч буй ААНБ-ын төлбөр тооцооны бүртгэлийг мөнгөн хөрөнгийн нярав өдөр бүр хийж, авлагын нягтлан бодогч 7 хоног бүр хянаж ажиллах.
- 5.2.10 Мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч, мөнгөн хөрөнгийн нярав нар нь авто жингийн бүртгэгчийн пүүний дэлгэрэнгүй тайлантай өдөр бүр хоорондын тооцоо болон бэлэн орлогын тооцоог тулгаж баталгаажуулах
- 5.3 Гадны автомашины жолооч нарын эрх
- 5.3.1 Дугаарлаж зогсох, жигнүүлэх, ачилтын цэгүүд рүү явах болон нүүрс ачуулах үед "Багануур" ХК-ийн ажилтан болон гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтнууд зүй бус шаардлага тавьсан тохиолдолд компанийн ҮБА, ХАБЭА-н хэлтэс, ДХША болон Дэд захирлуудад гомдлыг бичгээр болон утсаар гаргах.
- 5.3.2 Нүүрс ачуулах үед ачилтын талбай хазгай байх, ачилт хийх явцад автомашинд эвдрэл гэмтэл гарах нөхцөл бүрдвэл тухайн зөрчлийг арилгуулахыг тухайн тоног төхөөрөмжийн машинч, операторуудаас шаардах.
- 5.3.3 Нүүрс ачилтын талаар 5.3.1 заагдсанаас өөр санал, гомдлоо компанийн удирдах албан тушаалтан болон холбогдох албан тушаалтанд бичгээр гаргах.
- 5.4 Гадны машины жолооч нарын үүрэг
- 5.4.1 Нүүрс худалдан авахаар ирсэн автомашины жолооч нар нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх болон техникийн бичиг баримтын зөрчилгүй байх.
- 5.4.2 Нүүрсийг хаана буулгах тухай аймаг, сум, дүүрэг, баг, хорооны тодорхойлолтыг "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ" байгуулсан ААНБ нь гэрээний хугацаанд нэг удаа, иргэн нүүрс худалдан авах тухай бүр заавал авч ирэх.
- 5.4.3 Нүүрс ачихаар ирсэн автомашины жолооч нар "Багануур" ХК-иас тусгайлан зассан талбайд дугаарлаж зогсох.

- 5.4.4 Гадны автомашины жолооч нь гэрээт харуул хамгаалалтын ажилтанд машины гэрчилгээ болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхээ шалгуулан, аюулгүй ажиллагааны заавар бүхий дугаар авч, түүнийг уншиж танилцан уурхайн шалган нэвтрүүлэх 12-р постоор нэвтрэх
- 5.4.5 Жолооч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцох бөгөөд компанийн нутаг дэвсгэрт 30 км/цагаас дээш хурдтай явахгүй байх.
- 5.4.6 Жолооч нь компанийн нутаг дэвсгэрт нэвтэрхээс өмнө болон нэвтэрсэний дараа мөрдөж байгаа дарааллыг баримтлан эмх журамтай байж хог хаягдал хаяхгүй байх.
- 5.4.7 Жолооч нь ачаагүй үеийн жинг бүртгүүлэн гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтнуудын зааж өгсөн талбайд очин нүүрсээ автомашины даацанд тохируулан ачилт хийлгүүлэх буюу гараар ачих
- 5.4.8 Складнаас жолооч өөрөө гараар нүүрс ачихдаа өөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, хариуцан ажиллах ба орохыг хориглосон мөргөцөгөөс гараар нүүрс ачихгүй байх
- 5.4.9 Нүүрсний мөргөцөгөөс нүүрс ачуулах үед нүүрс ачилтын экскаваторуудаар ачуулж байгаа компанийн хүнд даацын автосамосвалуудын ажилд саад учруулахгүйгээр зам чөлөөлж зогсох ба дарааллыг баримтлан, талбай чөлөөтэй болсон үед тухайн экскаваторын машинч, туслах, операторын зөвшөөрлөөр ачилтын талбайд орж нүүрс ачуулах.
- 5.4.10 Экскаваторын машинчийн өгсөн дуут дохиогоор нүүрс ачуулахаар байрлалаа эзэлж, ачилт дуусч дохио өгсөний дараа хөдөлнө. Ачилт хийж байх үед автомашины тэвш дээр гарах, нүүрсийг өрж хураах, экскаваторын эргэлтийн радиус дотор орохгүй байх ба кабинаасаа гарч аюулгүй зайд хүлээх.
- 5.4.11 Жолооч нар нь автомашинаа уурхайн технологийн машин механизмаар чирүүлэх, зам хааж зогсох зэргээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.
- 5.4.12 Уурхайн талбайгаар дур мэдэн сэлгүүцэхгүй байх, хулгай хийх, хэв журмын зөрчил гаргахгүй байх ба компанийн дүрэм журамд захирагдан дагаж мөрдөх.
- 5.4.13 Нүүрс ачуулсны дараа авто жин дээр ажиллаж байгаа жингийн бүртгэгчийн зааврыг баримтлан авто жингээр ачаатай үеийн буюу нүүрсний жинг тогтоолгох.
- 5.4.14 Хоорондын тооцоогоор нүүрс авах автомашины жолооч нар ачаа жингийн хуудсан дээр мөнгөн хөрөнгийн няраваар зөвшөөрсөн тэмдэглэл хийлгэж тамгаар баталгаажуулсан байх.
- 5.4.15 Гадны автомашины жолооч нь тодорхойлолт, ачаа жингийн хуудсаа СЭЗБХ-ийн мөнгөн хөрөнгийн нягтлан бодогчид үзүүлэн кассын орлогын баримт авч дээрхи баримтуудыг мөнгөн хөрөнгийн няравт хүлээлгэн өгч төлбөрөө төлөх

- 5.4.16 Жолооч нь компаниас гаргасан цагийн хуваарийн дагуу шалган нэвтрүүлэх 12-р постоор гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтны зөвшөөрлийн дагуу холбогдох баримт бичгийг шалгуулан орох ба буцаж гарах
- 5.5 ҮБА-ны эрх
- 5.5.1 ҮБА нь нүүрс борлуулалтын холбоотой бүхий л асуудлыг шийдвэрлэх
- 5.5.2 Ээлжийн дарга нь гадны автомашиныг хаанаас ачих боломжтойг уулын хэсгүүдийн удирдлагуудтай зөвлөж ажлыг шуурхай зохион байгуулан гэрээт харуул хамгаалалтын алба болон авто жингийн бүртгэгчид мэдэгдэж нүүрс авахаар ирсэн автомашинуудыг оруулах чиглэл, зөвшөөрлийг өгөх.
- 5.5.3 Авто жингийн бүртгэгч нь ээлжийн даргын өгсөн нарядын дагуу автомашинуудын ачаагүй үеийн жинг жигнэхэд дараалал баримтлаагүй жолоочийн автомашиныг жигнэхгүй байх.
- 5.5.4 Авто жингийн бүртгэгч нь нүүрсийг хаана буулгах газрын тодорхойлолтыг шаардах
- 5.5.5 ТехноБХ-ийн маркшейдертэй хамтран авто жингийн үйл ажиллагаа саатсан тохиолдолд ачсан нүүрсийг хэмжих
- 5.6 ҮБА-ны үүрэг
- 5.6.1 Автомашинуудыг жигнэх үйл ажиллагааг эмх журамтай зохион байгуулах
- 5.6.2 Хоорондын тооцоогоор нүүрс авч буй ААНБ-н автомашины жолооч нарт авто жингийн ажилтан нь ачаа жингийн хуудсыг гурван хувь үйлдэж олгох
- 5.6.3 ҮБА-ны дарга нь гадны автомашины ачилтын үйл ажиллагаанд хяналт тавьж бүхий л зөрчил дутагдалыг арилгах, гарсан санал, гомдлыг судлан шийдвэрлэх.
- 5.6.4 Уулын тоног төхөөрөмж хариуцсан диспетчер гадны машинд нүүрс ачих үйл ажиллагааны талаархи мэдээллийг ТДЗ, ҮТЭДЗ, ХАБЭАХ, ҮБА-ны дарга нарт мэдээлж байх.
- 5.6.5 Авто жингийн бүртгэгч нь Монгол улсын Засгийн газрын 2018 оны № 62 тоот тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нүүрс худалдан авч буй ААНБ болон иргэнээс нүүрсийг хаана буулгах тухай аймаг, сум, дүүрэг, баг, хорооны тодорхойлолтыг шаардан авч жингийн хуудас олгох ба өдөр бүр бэлэн мөнгөний няравтай тооцоо нийлж авто жингийн дэлгэрэнгүй тайланг хүлээлгэн өгч байх.
- 5.6.6 Автомашинаар нүүрс худалдан авч байгаа хэрэглэгч нарын санал хүсэлтийг өдөр бүр шуурхай шийдвэрлэж байх.
- 5.7 Бусад хэлтэс хэсгүүдийн эрх
- 5.7.1 ХАБЭА хэлтэс нь удаа дараа зөрчил гаргасан, тавьсан шаардлага биелүүлдэггүй, залилж мэхэлдэг жолооч нарыг дахин ачилтанд оруулахгүй байх хүртэл арга хэмжээг гэрээт харуул хамгаалалтын албатай хамтран хэрэгжүүлэх.
- 5.7.2 ДХША-нь гэнэтийн шалгалт хийх

- 5.7.3 Бусад хэсэг, хэлтсүүд нь гадны машинд нүүрс ачих, худалдахтай холбоотой санал хүсэлтээ удирдлага болон холбогдох албан тушаалтанд тавих
- 5.8 Бусад хэлтэс, хэсгүүдийн үүрэг
- 5.8.1 Уулын хэсгийн удирдлагууд нь гадны автомашины ачилтын байдалд хяналт тавьж үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр гадны машинд нүүрс ачих ажлыг зохион байгуулах.
- 5.8.2 Экскаваторын машинч, гидро экскаватор болон дугуйт ачигчийн операторууд нь ээлжийн дарга болон ээлжийн мастер нарын өгсөн үүрэг, зааврын дагуу гадны автомашинд ачилт хийх.
- 5.8.3 Экскаваторын машинч, туслах машинч, ачигчийн оператор нар аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөж ажиллах, гадны автомашины тэвшнээс дээш 20 см-ээс өндөргүй ачилт хийх ба уурхайн хүнд даацын автосамосвалуудыг эхний ээлжинд ачих
- 5.8.4 Экскаваторын машинч, дугуйт ачигчийн оператор, урвуу утгуурт экскаваторын операторууд гадны автомашинуудад нүүрсийг ачихдаа тухайн мөргөцөг, нүүрсний склад орчмын аюулгүй ажиллагааг хангаж ачилтыг хийх.
- 5.8.5 Автосамасвал, бульдозер, грейдер, зам усалгааны машин, үйлчилгээний машины жолооч нар гадны автомашиныг чирэх болон ямар нэг байдлаар гадны автомашины жолооч нарт үйлчлэхгүй байх.
- 5.8.6 ТАМАХ нь гадны автомашины орж гарах замын тэмдэг тэмдэглэгээг тухай бүр хийж ажиллах ба дугуйт ачигчаар авто машинд нүүрс ачих үед ХАБЭА-г мөрдөж ачих.
- 5.9 Гэрээт харуул хамгаалалтын албаны эрх
- 5.9.1 Гэрээт харуул хамгаалалтын ажилтан нь шалган нэвтрүүлэх 12-р постоор гадны автомашины жолооч нарын бичиг баримтыг шалгаж оруулах
- 5.9.2 Шалгах үед согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн жолоочийг үйлдвэрлэлийн талбайд нэвтрүүлэхгүй байх
- 5.9.3 Компаний талбайд зөрчил гаргасан жолоочийг сануулах ба дахин зөрчил гаргавал дахин нэвтрүүлэхгүй байх
- 5.10 Гэрээт харуул хамгаалалтын албаны үүрэг
- 5.10.1 Гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтан нь жолооч, тээврийн хэрэгслийг шалгах явцад зөрчил илэрсэн тохиолдолд ХАБЭА-н хэлтэс болон Уурхайн төв диспетчерт мэдээлэх.
- 5.10.2 “Багануур”ХК нь ажилтнууддаа олгож буй нүүрсэнд явж буй автомашины гэрээ, дүүргийн зорилтод бүлгийн иргэн нүүрс авч буй бол хорооны тодорхойлолт зэргийг үндэслэн дугаар харгалзахгүй оруулах
- 5.10.3 Автомашины ачаагүй үеийн жинг нэмэгдүүлэх зорилгоор цемент чулуу, элдэв хог ачсан, пүүний жигнэх тавцангаас илүү гарахаар урт буюу 16м-с урттай тээврийн хэрэгслийг ачилтанд оруулахгүй байх.

- 5.10.4 Уурхайн гаднах талбай, авто пүү, нүүрсний склад, нүүрс гаргалтын амнуудад харуул хамгаалалтын ажилтнуудаа байрлуулан хяналт тавьж ажиллах.
- 5.10.5 Гараар нүүрс ачих иргэдийг уурхайн олборлолтын ам руу оруулахгүй байх ба жижиг оврын болон чиргүүлтэй автомашинуудыг зөвхөн складнаас нүүрс ачуулах.
- 5.10.6 21:00 цагаас өмнө уурхайн талбайгаас гарч чадаагүй автомашины шалтгааныг тогтоон заагдсан талбайд хонуулан дараа өдөр нь ажлын цагт багтаан гаргах арга хэмжээ авах.
- 5.10.7 Зөрчил гаргасан жолооч нарын бүртгэл хөтөлж ХАБЭА-н хэлтэс, ҮБА-нд мэдээлэх

ЗУРГАА. ХЯНАЛТ

- 6.1 Ээлжийн дарга гадны автомашинд нүүрс ачих үйл ажиллагаанд хяналт тавьж тоног төхөөрөмжүүдэд эвдрэл гарах, зөвөөр хийх зэрэг саатал гарсан үед зохицуулалтыг тухай бүр хийж ажиллана.
- 7.1 СЭЗБХ нь нүүрс, хайрга, хаягдал төмөрний төлбөр, Хоорондын тооцоогоор нүүрс авч буй ААНБ-д төлбөрт нь тохирох нүүрсний тооцоонд өдөр бүр хяналт тавина.
- 6.2 ҮБА нь гадны автомашинд нүүрс ачих үйл ажиллагааг түргэн шуурхай, зохион байгуулж хяналт тавьж ажиллана.
- 6.3 ХАБЭА хэлтэс нь гэрээт харуул хамгаалалтын албаны үйл ажиллагаа болон гадны машины ачилтын байдалд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.
- 6.4 ТАМАХ-ийн удирдлагууд гадны автомашинд нүүрс ачиж байх үед өөрийн харьяалалын хөдлөх бүрэлдэхүүний ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 6.5 ҮАМХ болон ЗХ-гүүд гадны автомашиныг өөрийн ажлын байр, объектонд оруулах, засвар үйлчилгээ хийхийг хориглох ба тухайн хэсгүүдийн удирдлагууд ээлжийн механикууд хяналт тавина.
- 6.6

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.2 Энэхүү журмыг 2.1-д заасан этгээдүүд биелүүлж ажиллах ба хариуцлага алдсан тохиолдолд холбогдох хууль, журам болон компаний ажилчдад Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 7.3 Нүүрс авахаар ирсэн автомашины жолооч нь 5.4.1-ээс 5.4.16 хүртэлх заалтуудыг зөрчсөнөөс учирсан хохирлыг өөрөө бүрэн хариуцна.
- 7.4 Нүүрс авахаар ирсэн автомашины жолооч нарын машинд нүүрс ачих явцад эвдрэл үүсэж, эд материалын хохирол учирсан тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхойлон асуудлыг шийдвэрлэнэ.